

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хөдөлмөр
эрхлэлтэд үзүүлэх нөлөөг хэмжих нь

Б. Даваамаа

Агуулга:

- 1 Судалгааны зорилго, зорилт
- 2 Монгол улсын ХХДХ
- 3 Судлагдсан байдал
- 4 Онол, арга зүй
- 5 Тоон өгөгдөл
- 6 Үр дүн
- 7 Дүгнэлт

1 Судалгааны зорилго, зорилт


Энэхүү судалгааны ажил нь Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд ямар нөлөө үзүүлж байгааг судлах зорилготой.

Уг судалгааг хийх явцад дараах асуудалд хариу олохыг зорьсон болно. Үүнд:

- Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлдөг вэ?
- Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлдөг вэ?

1 Судалгааны зорилго, зорилт

Зураг 1 . Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, оноор, хувиар



2. Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

■ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) 131-р зөвлөмжид тодорхойлсноор “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь тодорхой хугацаанд гүйцэтгэсэн ажлын хөлсөнд ажил олгогчоос ажилтанд төлөх ёстой хөдөлмөрийн хөлсний хамгийн бага хэмжээ” юм. ХХДХ нь бага цалинтай ажилчдыг хамгаалах зорилгоор тогтоогддог ба үүнийг хамтын гэрээ болон хувь хүний гэрээгээр багасгаж бууруулах боломжгүй.

■ Монгол улсын ХХДХ-ний хуульд ХХДХ-г “Тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах гэрээгээр ажиллаж байгаа ажилтны хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалин /хөлс/-гийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаар” хэмээн тодорхойлсон байдаг.


2. Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

■ Монгол улс нь ХХДХ-г дараах хүчин зүйлсийг харгалзан тогтоох буюу өөрчилдөг. Үүнд:

- 1.Хүн амын өртгийн өөрчлөлт;
- 2.Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн зохистой харьцаа;
- 3.Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ;
- 4.Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээ;
- 5.Эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн түвшин;
- 6.Инфляцын түвшин; (Энэ заалтыг 2021 оны 7-р сарын 2-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2022 оны 1-р сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)


2. Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

Зураг 2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, батлагдсан оноор



2. Монгол улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

Зураг 3 . Ази, Номхон далайн орнуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ам.доллараар



Эх сурвалж: Global Wage Report 2020/21

3 Судлагдсан байдал

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөлөл нь олон улсын түвшинд өргөн хүрээтэй судлагдсан байдаг. Энэ нь мета-анализаар судлагдсан эдийн засгийн цөөн хэдэн салбаруудын нэг юм (Belman and Wolfson 2014; Doucouliagos and Stanley 2009; Neumark and Wascher 2007; Card and Krueger 1995, Brown et al 1982).

- Brown et al., (1982): 1%-3% хувиар буурсан.
- Card and Krueger (1994): Хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн.
- Card and Krueger (1995): Үр дүнгийн ялгаатай байдлыг тоон өгөгдөл, арга зүйн сонголт болон хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөөллийн талаарх сөрөг, статистикийн ач холбогдолтой тооцоог эрэлхийлэх судлаачид болон сэтгүүлийн редакторуудын хандлагаас үүдэлтэй гэж үзжээ.

3 Судлагдсан байдал

АНУ:

- Neumark and Wascher (1995): Өсвөр насны хүүхдүүд сургуулиа орхиж ажилд орох эсвэл илүү олон цагаар ажилладаг болохыг илрүүлсэн.
- Zavodny (2000): Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсний дараа ажилтай хэвээр байгаа өсвөр насны хүүхдүүдийн ажлын цаг нэмэгдэх хандлагатай байгаа нь бусад өсвөр насны хүүхдүүдийн ажлын алдагдлыг бууруулна гэж үзсэн.
- Gramlich (1976) ба Hungerford (2000): Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь аль ч насны бүлгийн ажилчдын хувьд бүтэн цагийн ажил эрхлэлтийг бууруулж, хагас цагийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлдэг хэмээн мэдээлсэн.
- Cunnigham (1981) нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнээр бүтэн цагийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт буурдаг гэсэн эсрэг үр дүнд хүрчээ.

3 Судлагдсан байдал

Хөгжиж буй орнууд:

Бразил:

- Fajnzylber (2001): Албан салбар-сөрөг нөлөө (0.05-0.08)
Албан бус салбар-сөрөг нөлөө (0.25-0.35)
- Lemos (2003): Хувийн хэвшил-ямар нэг нөлөөгүй
Төрийн байгууллага-ээрэг нөлөө
- Lemos (2009): Албан салбар-нөлөөгүй
Албан бус салбар-нөлөөгүй. Өөрөөр хэлбэл, Бразил улсын албан болон албан салбарт ажлын байрны тоо болон ажилласан цаг өөрчлөгдөөгүй.

Мексик:

- Feliciano (1998): Эрэгтэй-нөлөөгүй (55-64 насны эрэгтэйчүүд-ээрэг)
Эмэгтэй-сөрөг нөлөө (0.41-0.76)

3 Судлагдсан байдал

Хөгжиж буй орнууд:

Индонези

- Pratomо (2014): Эрэгтэй ажилчид- эерэг нөлөө (бага)-ажилласан цаг
Эмэгтэй ажилчид-эерэг нөлөө(өндөр) -ажилласан цаг
- Pratomа (2016): Индонези улсын хотод амьдардаг эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт албан салбараас албан бус салбар руу шилждэг бол эмэгтэйчүүдийн хувьд албан салбараас хувиараа хөдөлмөр эрхлэлт аль эсвэл цалингүй гэрийн хөдөлмөр руу шилжиж байна.

Өмнөд Африк

- Bhorat and Kanbur(2012): Тариаланчид-сөрөг нөлөө (13%)

3 Судлагдсан байдал

Хөгжиж буй орнууд:

Хятад

- Fang, Lin (2013): Зүүн болон Төвийн бүс: залуу эмэгтэй ажилчдад (15-29 нас) -хүчтэй сөрөг нөлөө
залуу эрэгтэй ажилчид (15-29 нас), (50- 64 нас)-нөлөөгүй

Энэтхэг

- Menon, Rodgers (2015): Хөдөө орон нутгийн эрэгтэй- эерэг нөлөө (6.34)

Хөдөө эмэгтэй- эерэг нөлөө(6.02)

Хотын ажилчид- нөлөөгүй

Түүгээр ч зогсохгүй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь хүйсийн цалингийн ялгааг нэмэгдүүлжээ.

Монгол

- Byambatsogt (2019): Албан салбар-эерэг нөлөө
Албан бус салбар-сөрөг нөлөө

3 Судлагдсан байдал

■ Дээрх судалгаануудын үр дүнгээс харахад Мексик, Индонези, Өмнөд Африк, Хятад улсуудын хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь эрсдэлт бүлгийн ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг бууруулж байгаа бол Энэтхэг болон Монгол улсын хувьд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлжээ.

■ Хөгжиж буй улсуудын хувьд хийгдсэн судалгаануудын үр дүн ялгаатай байгаагийн шалтгаан нь тухайн улсын хуулийн хэрэгжилт, албан бус салбарын хэмжээ, үйлдвэрчний эвлэл, өндөр инфляцын үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэн гэх мэт олон шалтгаанаас болж улс бүрийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөө өөр өөр байна.(Neumark and Wascher 2008)

4 Онол, арга зүй

4.1 Онол


Онолын хувьд эрэлт, нийлүүлэлтийн загвар нь ХХДХ-г судалдаг хамгийн энгийн суурь загвар юм. Уг загвар нь дараах таамаглалуудыг тавьдаг (Belman & Wolfson 2014) Үүнд:

- Хөдөлмөрийн зах зээлд дангаараа шууд нөлөөлж чадахуйц том пүүсүүд байхгүй ба зах зээл дээр олон пүүсүүд үйл ажиллагаа явуулдаг;
- Хөдөлмөрийн зах зээл олон ажиллагсадтай ба тэдгээрийн хэн нь ч цалин хөлс ба хөдөлмөр эрхлэлтэд нөлөө үзүүлэхгүй;
- Ажил олгогчид ХХДХ нэмэгдэхээс өмнө эсвэл дараа нь зардлаа багасгадаг.

4 Онол, арга зүй

4.1 Онол

Зураг 4 . Хөдөлмөрийн зах зээл дэх ХХДХ-ний нөлөө



D -Эрэлтийн муруй

S -Нийлүүлэлтийн муруй

W^* -Эрэлт нийлүүлэлтээр тодорхойлогдсон зах зээлийн тэнцвэрт цалин

E^* - Эрэлт нийлүүлэлтээр тодорхойлогдсон зах зээлийн тэнцвэрт хөдөлмөр эрхлэлт

$W^{\min}$ -Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

$E^{\min}$ - Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тогтоосны дараах хөдөлмөр эрхлэлт

E' - $W^{\min}$ цалингаар ажиллах сонирхолтой байгаа ажиллагсадын тоо

4 Онол, арга зүй

4.1 Эмпирик арга зүй

Энэхүү судалгаанд Neumark et al., (1995) болон Byambatsogt (2019) нараас зохиосон эмпирик тодорхойлолтыг ашигласан бөгөөд хувь хүний хөдөлмөр эрхлэх магадлалыг тодорхойлогч хүчин зүйлсийг дараах байдлаар илэрхийлэв:

$$y_{it} = \alpha + \beta_1 MW_t + \beta_2 X_{it} + \beta_3 Z_t + \beta_4 T_t + \varepsilon_{it}$$

- Хамаарах хувьсагч y_{it} нь i дугаар хүний t хугацааны хөдөлмөр эрхлэлт
- MW_t нь 2010 үнээр зэрэгцүүлсэн бодит хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний логарифм утга

4 Онол, арга зүй

4.1 Эмпирик арга зүй

- X_{it} нь хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн шийдвэрт нөлөөлдөг хувь хүн болон өрхийн шинж чанарын тайлбарлагч хувьсагчдын багц юм. Эдгээр шинж чанаруудад: хүйс, нас, насны квадрат, гэрлэлт, боловсролын түвшин (бүрэн бус дунд, бүрэн дунд, техникийн болон тусгай мэргэжлийн, бакалавр, ахисан түвшний боловсрол), өрхийн ам бүлийн тоо, туршлага (5-9 жил ажилласан, 10 дээш жил ажилласан), байршил (хөдөө) зэрэг багтана.
- Z_t – бодит ДНБ (2010 үнээр зэрэгцүүлсэн, лог), Ажилгүйдлийн түвшин болон Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын логарифм утга
- T_t нь жилийн дамми юм.

5 Тоон өгөгдөл

Энэхүү судалгаанд Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны Ажиллах Хүчний Судалгаа (АХС)-ны (2008-2018 оны) тоон мэдээллийг ашиглав.

5.1 Мэдээлэл боловсруулалт

АХС-ны 2008-2018 оны тоон мэдээллийг шинжилгээнд ашиглахад бэлэн болгохын тулд дараах боловсруулалтыг хийж гүйцэтгэлээ:

- Он тус бүрийн асуулгын хуудастай танилцаж, асуулгын хуудасны бүтцийн өөрчлөлтийг шалгасан;
- Он тус бүрийн зэрэгцүүлсэн тоо мэдээллийг, асуулгын хуудас, хувьсагчдын нэршлийн хамт ҮСХ-ны мэдээллийн сангаас татан авч R-studio програм руу оруулав;
- 2008-2018 оны он тус бүрийн асуулгын хуудас болон хувьсагчдын нэрсийг хооронд нь тулгаж, он тус бүрд байгаа өөр нэртэй адил хувьсагчдыг ижил нэртэй болгов;

5 Тоон өгөгдөл: Мэдээлэл боловсруулалт

- Хувьсагчдын хариултын кодыг он тус бүрийн асуулгын хуудсаар нь тааруулж хариултын кодыг нэг стандартад оруулж ижил болгон хувиргасан.
- Он тус бүрийн тоон мэдээлэлд анхан шатны боловсруулалт хийсний дараа тоон мэдээллүүдийг ижил нэртэй хувьсагчдаар нь нийлүүлж, 246 хувьсагчтай 414,539 ажиглалтын утгатай мэдээллийн санг байгуулав.
- Уг мэдээллийн сангаас хөдөлмөр эрхлэлтийн шинжилгээнд хэрэгцээтэй хувьсагчдыг онолын таамаглал болон эмпирик судалгааны ажлуудад суурилан сонгон авч мэдээллийн санг 15-64 насны хүн амаар хязгаарласан.
- Эцэст нь судалгаанд ашиглах мэдээллийн санг R-studio программаас stata програм руу оруулснаар шинжилгээ хийх 282,675 ажиглалтын утгатай тоон мэдээллийн сан бэлэн болсон. Мөн хугацаан цуваа тоо мэдээллийг улирлын давтамжтайгаар ҮСХ-ны мэдээллийн сангаас цуглуулан шинжилгээнд ашиглахад бэлэн болгосон мэдээллийн сантай нэгтгэлээ.

5 Тоон өгөгдөл: Дескриптив шинжилгээ

Хүснэгт 1 . Судалгаанд оролцогчдын ерөнхий төлөв байдал

	2008-2009		2018	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөдөлмөр эрхлэлт	0.6252	0.5326	0.6867	0.5606
Давхар хөдөлмөр эрхлэлт	0.0127	0.0069	0.0162	0.0115
Долоо хоногийн цалин	61900.05	54387.86	177862.5	141040.1
Долоо хоногийн ажилласан цаг	50.2	43.7	53.1	46.5
Нас	33.6	34.3	37.1	37.9
Өрхийн гишүүдийн тоо	4.2	4.2	4.02	4.04
Боловсрол:				
Боловсролгүй	0.0158	0.0102	0.0383	0.0253
Бүрэн бус дунд	0.3795	0.3135	0.2561	0.2035
Бүрэн дунд	0.3449	0.3501	0.1918	0.2143
Техникийн болон мэргэжлийн	0.1386	0.1701	0.3272	0.2532
Бакалавр	0.0998	0.1339	0.1758	0.2869
Ахисан түвшний	0.0072	0.0084	0.0108	0.0168
Гэрлэлтийн байдал:				
Гэрлээгүй	0.4169	0.4309	0.3391	0.3627
Гэрлэсэн	0.5831	0.5690	0.6609	0.6373
Туршлага:				
1-4 жил ажилласан	0.2252	0.1792	0.2406	0.1788
5-9 жил ажилласан	0.1306	0.1048	0.1295	0.1055
10 ба түүнээс дээш жил ажилласан	0.2694	0.2486	0.3165	0.2763
Байршил:				
Хот	0.3767	0.4075	0.2932	0.3127
Хөдөө	0.6233	0.5925	0.7068	0.6874
Ажиглалтын тоо	8,201	8,884	13,490	14,598

5 Тоон өгөгдөл: Дескриптив шинжилгээ

Хүснэгт 2. Сарын цалин болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний зөрүү, хувиар

Ангилал		2008-2009 оны Цалин ба ХХДХ			Ажиглалтын утга
		Бага	Тэнцүү	Өндөр	
Эрэгтэй	2008-2009	0.25342	0	99.74658	1,973
	2018	10.225	1.075	88.7	4,000
Эмэгтэй	2008-2009	0.42036	0	99.57964	2,141
	2018	11.96327	1.43956	86.59717	4,029
Нийт	2008-2009	0.3403	0	99.6597	
	2018	11.09727	1.25794	87.64479	8,029

5 Үр дүн

Хүснэгт 3. Хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үр дүн

Хувьсагчид	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
ХХДХ (Бодит, лог)	-0.0328*** (0.0114)	-0.0312* (0.0165)	-0.0324** (0.0158)
Хүйс (эмэгтэй)	-0.0747*** (0.0012)	-	-
Нас	0.0383*** (0.0003)	0.0349*** (0.0004)	0.0406*** (0.0005)
Насны квадрат	-0.0006*** (0.0000)	-0.0005*** (0.0000)	-0.0006*** (0.0000)
Өрхийн гишүүдийн тоо	-0.0062*** (0.0004)	-0.0042*** (0.0006)	-0.0090 *** (0.0006)
Боловсрол: (Суурь бүлэг=боловсролгүй)			
Бүрэн бус дунд	0.0702*** (0.0045)	0.0522*** (0.0059)	0.0919*** (0.0073)
Бүрэн дунд	0.0679*** (0.0045)	0.0477*** (0.0059)	0.0915*** (0.0072)
Техникийн болон мэргэжлийн	0.1532*** (0.0045)	0.1341*** (0.0059)	0.1744*** (0.0072)
Бакалавр	0.1859*** (0.0045)	0.1689*** (0.0059)	0.2061*** (0.0071)
Ахисан түвшний боловсрол	0.2270*** (0.0083)	0.2266*** (0.0133)	0.2353*** (0.0111)
Гэрлэлтийн байдал: (Суурь бүлэг=Гэрлээгүй)			
Гэрлэсэн	0.0364*** (0.0016)	0.0930*** (0.0024)	-0.0054*** (0.0021)

5 Үр дүн

Хүснэгт 3 үрг . Хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үр дүн

Туршлага: (Суурь бүлэг= 1-4 жил ажилласан)			
5-9 жил ажилласан	0.7344*** (0.0214)	0.7326*** (0.0356)	0.7288*** (0.0262)
10 ба түүнээс дээш жил ажилласан	0.8221*** (0.0160)	0.7931*** (0.0235)	0.8364*** (0.0229)
Байршил: (Суурь бүлэг=Хот)			
Хөдөө	0.0432*** (0.0013)	0.0353*** (0.0019)	0.0502*** (0.0018)
Макро үзүүлэлтүүд:			
БДНБ (лог)	0.0091* (0.0055)	0.0108 (0.0079)	0.0069 (0.0076)
ГШХО (лог)	0.0046** (0.0025)	0.0076** (0.0035)	0.0015 (0.0034)
Ажилгүйдлийн түвшин	-0.0039*** (0.0008)	-0.0048*** (0.0012)	-0.0031*** (0.0011)
Ажиглалтын тоо	282,675	137,058	145,617
Pseudo-R2	0.5101	0.4928	0.5247
Prob > chi2	0.0000	0.0000	0.0000
Multicollinear test: VIF	8.93	9.00	9.55
Wald test:	0.0000	0.0000	0.0000

Тэмдэглэл: Хугацааны дамми оруулсан үнэлгээ; ***, **, * тус бүр 1%, 5%, 10%-ийн түвшинд ач холбогдолтой; ()-тэсвэртэй стандарт алдаа.

6 Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар Монгол улсын хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт нь ХХДХ-ний өөрчлөлтөд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгааг судаллаа. Судалгааны үр дүнгээс харахад хууль тогтоомжоор тогтоосон ХХДХ нь эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хувьд хөдөлмөр эрхлэх магадлалд сөрөг ба статистикийн хувьд чухал нөлөө үзүүлж байна.

■ Хөдөлмөрийн насны хүмүүсийн хөдөлмөр эрхлэх магадлалтай хүйс, насны квадрат, өрхийн гишүүдийн тоо болон ажилгүйдлийн түвшин зэрэг нь сөрөг, харин нас, боловсролын түвшин, гэрлэлт, ажилласан жил, БДНБ, ГШХО болон хөдөө амьдардаг байх нь эерэг хамааралтай байна.

■ Бодит ХХДХ 10 хувиар өсөхөд хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх магадлал 0.324 хувиар, хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх магадлал 0.312 хувиар буурч байна. Өөрөөр хэлбэл, ХХДХ нь хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх магадлалыг маш багаар бууруулдаг гэсэн үг. Энэ нь Индонез, Мексик, Өмнөд Африк, Хятад улсын судалгаануудын үр дүнтэй нийцтэй байна.

Ашигласан материал

- Brandyn, Churchill F. & Joseph, Sabia J. 2018, “ Minimum Wages and Low-Skilled Immigrants: New Evidence on Earnings, Employment and Poverty” Available at: (10) The Effects of Minimum Wages on Low-Skilled Immigrants’ Wages, Employment, and Poverty (researchgate.net)
- Charles Brown, Curtis Gilroy and Andrew Kohen 1982, “The Effect of The Minimum Wage on Employment and Unemployment”, Journal of Economic Literature , Jun., 1982, Vol. 20, No. 2, pp. 487- 528
- Dale Belman & Paul J. Wolfson 2014, “What Does the Minimum Wage Do?”, W.E. Upjohn Institute for Employment Research, Available at : <https://doi.org/10.17848/9780880994583>
- Ronald B. Mincy 1990, “Raising the minimum wage: effects on family poverty”, Monthly Labor Review , Vol. 113, No. 7 (July 1990), pp. 18-25

Ашигласан материал

- Dale L. Belman & Paul Wolfson 2010, “The Effect of Legislated Minimum Wage Increases on Employment and Hours: A Dynamic Analysis”, LABOUR, Vol. 24, No.1, pp.1–25
- David Card and Alan B. Krueger 1995, “Time-Series Minimum-Wage Studies: A Meta-analysis”, The American Economic Review , Vol. 85, No. 2, pp. 238-243
- David Neumark and William Wascher 1995, “Minimum-Wage Effects on School and Work Transitions of Teenagers”, American Economic Review , May, 1995, Vol. 85, No. 2, pp. 244-249
- David Neumark and William Wascher 2006, “Minimum Wages and Employment: A Review of Evidence from the New Minimum Wage”, NBER Working Paper, No. 12663
- David Neumark, Mark Schweitzer and William Wascher 2004, “Minimum Wage Effects throughout the Wage Distribution” , The Journal of Human Resources , Vol. 39, No. 2 (Spring, 2004), pp. 425-450

Ашигласан материал

- David, Card & Alan, Krueger B. 1994, “Minimum Wages and Employment: A Case Study of the Fast-Food Industry in New Jersey and Pennsylvania”, The American Economic Review, Vol. 84, No. 4, pp. 772-793
- Devanto Pratomo 2011, “The Effects of Changes in Minimum Wage on Employment in Indonesia: Regional Panel Data Analysis” International Research Journal of Finance and Economics, Issue 62
- Donald Deere, Kevin M. Murphy and Finis Welch 1995, “Employment and the 1990-1991 Minimum-Wage Hike”, The American Economic Review, Vol. 85, No. 2, pp. 232-237
- Russell S. Sobel 1999, “Theory and Evidence on the Political Economy of the Minimum Wage”, Journal of Political Economy, Vol. 107, No. 4, pp. 761-785

Ашигласан материал

- Edward M. Gramlich, Robert J. Flanagan and Michael L. Wachter 1976, “Impact of Minimum Wages on Other Wages, Employment, and Family Incomes”, Brookings Papers on Economic Activity, Vol. 1976, No. 2, pp. 409-461.
- Haroon Bhorat & Ravi Kanbur & Benjamin Stanwix 2015, “Estimating the Impact of Minimum Wages on Employment, Wages and Non-Wage Benefits: The Case of Agriculture in South Africa”, Working Paper, No. 5
- Sara Lemos 2009, “Minimum wage effects in a developing country”, Labour Economics, Vol. 16, pp. 224-237
- Tony Fang Carl Lin 2013, “Minimum Wages and Employment in China”, IZA World of Labor-Discussion paper series, No. 7813
- Pablo Fajnzylber 2001, “Minimum Wage Effects Throughout the Wage Distribution: Evidence from Brazil’s Formal and Informal Sectors”, Available at: http://papers.ssrn.com/paper.taf?abstract_id=269622

Ашигласан материал

- Hristos Doucouliagos and T. D. Stanley 2009, Publication Selection Bias in Minimum-Wage Research? A Meta-Regression Analysis, British Journal of Industrial Relations, Vol.47 No.2, pp. 406–428
- Lisa Daniels & Nicholas Minot 2018, An Introduction to Statistics and Data Analysis Using Stata, First edition, Karen Wiley, United States of America.
- Madeline Zavodny 2000, “The effect of the minimum wage on employment and hours”, Labour Economics, Vol.7, pp.729–750
- Nidhiya Menon & Yana van der Meulen Rodgers, The Impact of the Minimum Wage on Male and Female Employment and Earnings in India , Asian Development Review, Vol. 34, No. 1, pp. 28–64
- Үндэсний статистикийн хороо 2021, Аж ахуй нэгж, байгууллагын ажилёдын сарын дундаж цалин 2020, Электрон үүсвэр:https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=%D0%94%D1%83%D0%BD%D0%B4%D0%B0%D0%B6_%D1%86%D0%B0%D0%BB%D0%B8%D0%BD.pdf&ln=Mnttp://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=2018_LFS_report.pdf&ln=Mn